

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭНЭТЭМБЕР УХЛААНЫ ФАКУЛЬТЕТ

ТҮҮХ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ № 488 (14) 2002 он

RUSSIA



Гарчиг

Эрхэм уншигч Танаа

5

Монголын түүх

1. П.Дэлгэржаргал. Мэнгу шивэй аймгийн угсаа гарлыг нэхэн сурвалжлах нь. 8
2. Д.Хүүхэнбаатар, П.Дэлгэржаргал. Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөний түүхийн асуудал. (XX зууны эхний хагас). 12
3. Д.Энхцэцэг. Үндэсний эв нэгдэл- тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн баталгаа болох нь. 18
4. Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь гадаадынхны үйл ажиллагаа. 23
5. З.Лонжид. Дундат иргэн улсаас Монголын тухай баримталсан бодлогыг нэхэн судлахуй. (1919 оноос хойш) 29
6. С.Отгонжаргал. XX зуунд Монголд гарсан хөрөнгөлөг ардчилсан хувьсгалын асуудалд. 34
7. Н.Хишигт. Монголын түүхэнд Барон Унгерний холбогдох нь /1921-1925/ 42
8. Б.Пунсалдулам. Монгол дахь Буриадын хурал. 51

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

1. Б.Ралгаа. Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн нь. 57
2. С.Түвшин. Ж.Цэвээний улс төр, нийгэм-эдийн засгийн үзэл баримтлалын тухайд. 68
3. З.Баасанжав. МУИС байгуулагдсан түүхээс. 73
4. Л.Ариунаа. Монголд өөрөө удирдах ёсны түүхэн уламжлал байсан уу? (Бодрол, тэмдэглэл). 78

Байгаль хамгаалах түүхэн уламжлал

1. Ж.Болдбаатар, С.Дэмбэрэл. Монголчуудын байгаль орчноо хамгаалах зан заншил, хууль тогтоомжийн түүхэн тойм (Нэн эртнээс XX зуун). 80
2. Л.Чулуунбаатар. Ган зудын гамшиг, гэтлэн давах арга замын тухайд. 99

Гадаад харилцааны түүх

1. Ута Шёне. 1920-иод онд Герман улсад суралцаж байсан монгол сурагчдад болон Лайпцигт хэвлүүлсэн монголын газрын зургийн түүхэнд холбогдох зарим тэмдэглэл. 104
2. Р.Төрдалай. Франц улсын Парис хотын монгол сурагчид /Түүхэн тэмдэглэл/. 110

Түүх бичлэг

1. Удо Баркманн. Монголын түүхийн талаархи олон улсын судалгаа: Эзгүйрэл, улс төрийн ашиг хонжоо хоёрт идэгдсэн Монголын түүх. 114
2. Б.Пунсалдулам. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын тухай түүх бичлэгийн зарим асуудалд. 127

Түүхэн газар зүй

1. Д.Сүхбаатар. Монгол орны түүхэн газар усны нэрийн тухай. 133

Хавсралт

1. Түүхийн салбарыг төгссөн алдартнууд 137
2. Зохиогчдын товч танилцуулга 139

**Ж.Цэвээний улс төр, нийгэм-эдийн засгийн
үзэл баримтлалын тухайд**

Докторант С.Түвшин /МУИС/

Ж.Цэвээн /1881-1942 он/ бол Монголын түүхэнд баларшгүй ул мөрөө үлдээсэн нийгэм-улс төрийн нэрт зүтгэлтэн, билгүүн номч эрдэмтэн, нэрт соён гэгээрүүлэгч хүмүүн байлаа. /1/

Ж.Цэвээний нийгэм-улс төрийн үзэл санаа нь агуу их Орос орны хязгаар нутаг болох Буриад, түүнчлэн угсаа гарвал, түүх, соёл нэг монголчуудын голомт нутаг Халх Монголд нийгмийн эрээвэр хураавар, ээдрээ будлиантай нөхцөлд бүрэлдэн тогтжээ.

Тэрээр Их Оросын шовинизм, жижиг буурай ястан, үндэстний үндсэрхэг үзэл, панмонголизм, буддизм, эв хамтын үзэл санаа, социал-демократизмын нөлөө, дайралтын аль алинийг амсаж, тэр бүхний дундаас өөрийн гэсэн үзэл ухал, байр сууриа тодорхойлохыг эрмэлзэж байв.

Чингээд Ж.Цэвээний улс төр, нийгэм, эдийн засгийн үзэл баримтлалын хувьд үндэсний ардчилсан чиг шугамыг сонгон авсан юм.

Ж.Цэвээний улс төрийн үзэл баримтлал нь үндэсний ардчилсан шинжээс хувьсгалт ардчилсан үзэл рүү шилжих хандлагатай байсан байна.

Тэрээр 1911 оны монголын үндэсний хувьсгалын үйл хэрэгт идэвхийлэн оролцож аливаа асуудлыг үндэсний ардчилсан байр сууринаас тодорхойлохыг оролдож байв. Тэрхүү оролдлого нь монголчуудыг соён гэгээрүүлэх тухайд хийж байсан ажил, гадаад харилцааг өргөтгөх талаар гаргасан чармайлт, “Улсын эрх” зэрэг, ном өгүүлэлд дэвшүүлсэн үзэл санаа зэргээс тодорхой харагддаг.

Ж.Цэвээн 1917 оны Оросын хувьсгалт эргэлтийн нүргээнд жилүүдэд тэнд ажиллаж амьдран нийгмийн ороо бусгаа байдлыг гүнзгий ухаарчээ. Тэрээр энэ эрчээрээ Монгол оронд 1920-иод өрнөсөн улс төрийн үйл явдалд оролцсон юм.

Ж.Цэвээн Монголд анхны улс төрийн нам –МАН-ыг үүсгэн байгуулахад идэвхийлэн оролцож, анхны мөрийн хөтөлбөрийг боловсуулахад голлон зүтгэж, нийгмийг хувьсгалын замаар өөрчлөх аргыг сонгожээ. Тэрхүү мөрийн хөтөлбөрт: “Монголын ард олны эрх мэдлийг эрхэмлэх, монголын төрийг босгох хэмээсэн энэхүү хоёр зүйлийн хэргийг бүрэн бүтэн гүйцэтгэхэд манай ардын намаас бошгыг халах намын бат журмаар үйлдэнэ” /2,35/ гэж заасан байна.

Тэрээр намын анхны мөрийн хөтөлбөрт: “...засгийн эрх мэдлийг ард түмэнд шилжүүлэн авч, ардын хуралт сонгуулийг эрхэлсэн гүрэн байгуулбал зохино” /2,35/ гэж томъёолол оруулсан нь ардын эрхт бүгд найрамдах засгийн тухай үзэл санааг дэвшүүлсэн хэрэг бөгөөд үүдэн сэдэж буй хувьсгал нь ардчилсан шинжтэй байхыг илэрхийлсэн агуулгатай байв. Хувьсгалын өрнөл хөгжил ч ийм замаар шийдэгдсэн билээ.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараа Ж.Цэвээн нам, төрийн удирдах албанд хичээнгүйлэн зүтгэж, БНМАУ-ын I Үндсэн хуулийг боловсруулах ажилд оролцжээ. Эл Үндсэн хуулийн улс төрийн үзэл санааны цаад цөм нь хувьсгалт ардчилсан үзэл болж байв. Түүний улс төрийн үзэл бодол нь Коминтерний чиг шугамтай зөрчилдөж, үндэсний болон хувьсгалт ардчилсан үзлийн зааг дээр оршиж байсан гэж болохоор байна. Коминтерн ч Ж.Цэвээнийг сталинист чиг шугамаас зүг буруулж байгааг тандаж, Монгол дахь өөрийн төлөөлөгчөөсөө “Б.Цэрэндоржийн дотоод сэтгэлийн илрэл буюу “барометр” нь Ж.Цэвээн” (3) гэсэн үнэлэлт гаргуулан авч байлаа.

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

Ж.Цэвээн гадаад улс төрийн бодлогын хувьд Монгол улс: "СССР, хятад хоёр улсаас баталсан бөгөөд бусад олон улсаас зөвшөөрөн хүлээсэн төвийг сахих улс болох хэрэгтэй. Энэ нь үлгэрлэвээс Швейцарь лугаа адил болой." хэмээн бичиж байлаа. Хэдийгээр империалист хүрээлэлд оршиж бэрх хэцүү байсан ч төвийг сахих гэж оролдон чармайх нь олон улсын анхаарлыг илүү татах, хүчний тэнцвэрийг барих боломжтой байсан байж ч болох юм.

Ж.Цэвээн шашны үзлийн хувьд буддизмыг марксизмтай ижил төстэй талаар нь адилтгаад, олон эшт үзлийн үүднээс нийлэгшүүлэн үзэж байжээ. Тэрбээр бичихдээ: "Үлэмж их Готома эв хамт ёсны тухай төгс сургаалийг хорвоо ертөнцөд хайрлан соёрхжээ. . . түүний эдүгээ үеийн ойлголт нь Готомагийн буддагаас Ленин хүртэлх үзэсгэлэнт гүүр тавьж байна. Тухайбал зориг төгөлдөр байх ёс, ангийн болон гадаад ялгамжийг үл харгалзан бие хүний нэр төрийг хүндэтгэх ёс, бодит эрдэм мэдлэгийг дээдлэх ёс, өөрөө ухамсарлан бусдыг энэрэн хайрлахуй эдгээр ёс нь суут багш нарын гэрээслэлийг хүн төрөлхтний баяр баясгалангийн тасралтгүй солонго болгож байна. Жинхэнэ буддын сургаалыг Ленин яаж үнэлж байсныг бид мэднэ: Бид түүний гэрээслэлийн дагуу Буддын сургаалын үндсүүдийг бүтээн байгуулах болно"(4,1) гэжээ. Ийнхүү тэрээр бурхны шашны шинэтгэл хийх, бүр марксизмын үзэл санаатай зохиролдуулан гүн гүнзгий өөрчлөх бодолтой байсан юм.

Тэрээр К.Марксын шашныг "хар тамхи" гэсний утга учрыг өвөрмөц байдлаар тайлбарлаж байв. Ж.Цэвээн: "шашныг хар тамхины хорт утаа" гэж хэмээсэн нь тусгай учиртай бөгөөд энэ нь зөвхөн христос, лал мэт эзэрхэг суртлын шашинд өгсөн үнэлэлт, иймийн тул манай бурхны сургаалд огт хамаарахгүй. Хэрэв К.Маркст буддын сургаалын талаар арвин баримт сэлт байсан бол тэрээр сонирхолтой дүгнэлт хийх байсан нь эргэлзээгүй" гэжээ.

Профессор Ж.Цэвээн байгаль, дэлхийг жам ёсны дагуу хөгждөг, дэлхий ертөнц хумхийн тоосноос бүрэлдэн тогтсон, өөрөө байнга хувьсан өөрчлөгдөж байдаг, нар дэлхийг тойрдоггүй, дэлхий бөөрөнхий хийгээд нарыг тойрдог гэх зэрэг байгалийн шалтгаант олон үзэгдлийн тухай, мөн хамаг амьтны энэрч хайрлах, амар амгаланг тогтоох тухай санааг эртний буддын гүн ухааны өвөөс олж харсан юм. Ийнхүү сайхь нийгэм, улс төрийн зүтгэлтэн зуун зуун дамжин ирсэн ард олны эрх чөлөөний эрмэлзлэл, мөрөөдөл, шүтлэг, мэдлэг, туршлага бүхнийг цагаантай, хартай нь нийлэгшүүлэн цогцлуулахыг эрмэлзэж, бурхны шашны үзэл санааг авах, гээхийн үүднээс хандан, тунгааж ариунаар мандуулах зорилго бодолтой хүн байжээ.

Ж.Цэвээн ". . . Төв Азийн газар оронд явуулбал зохих хоршооллын нийгэм журмын ёс" буюу "Монголын социалист хөгжлийн онцгой зам" (5) гэсэн үзэл баримтлалыг боловсруулах оролдлого хийжээ. Энэхүү оролдлогын гол агуулга нь тус орны эдийн засгийн хөгжлийн асуудлууд байв. "Хоршооллын социализм"-ын тухайд Ж.Цэвээний эдийн засгийн баримтлалын гол цөм нь Монгол орон хоршоолол, улсын капитализмаар дамжин социализм шилжин орох явдал байв. Тухайлбал: хувийн аж ахуйтныг дэмжих, ядуучуудыг дундчуудын хэмжээнд хүргэх (100 хүртэл бодтой), дундчууд болон баян чинээлэг аж ахуйтан ажиллах хүчин мөхөсдөж ирэхлээр өөрсдөө зайлшгүйгээр хоршооллын тогтолцоонд урган орно. Түүхий эд, өргөн хэрэглээний асуудал бүгд хоршоололд хамрагдсан санхүү, зээлийн систем, улсын банкны гарт, албан татварын тогтолцоо нь хувийн хөрөнгөлөг этгээдүүдийг хэрэг дээр нь хавчихад чиглэгдсэн учир иймийн тул 200-300, түүнээс дээш бодтой дунд ба баян чинээлэг аж ахуйтнууд хоршоололд хамрагдана гэж тэрээр үзэж байв. Түүнчлэн ой мод, газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүн гаргадаг, мөн түүхий эд боловсруулдаг үйлдвэр, тээвэр, холбоо, барилга, ер нь нийт үйлдвэрийн салбар улсын капитализмд хамрагдах

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

ёстой. Ийнхүү “хувийн болон баян чинээлэг мөн нударган аж ахуйтан амьдралын явцаар хоршооллын смстемд урган орохын зэрэгцээ ерөөс монгол улс ч бүхэлдээ хоршооллын болон улсын капитализмын аж ахуйн системд гарцаагүй багтан орно” гэж үзэж байжээ.

Ж.Цэвээн улсын эдийн засгийг хөгжүүлэх, бэхжүүлэх чухал хүчин зүйл бол харилцан туслалцах хоршоог байгуулж бүх талаар улсаас дэмжих явдал гэж үзэж байлаа. Чингээд улс орны эдийн засгийг хөгжүүлэх шинжлэх ухааны судалгаа шинжилгээ нэн чухал гэж үзээд “Эдийн засгийг хөгжүүлэхэд дэлхийн баялагийг ашиглах нь нэн чухал болох учир манай Судар бичгийн хүрээлэнгээс олон газрын ой мод зэргийг элдэв бодисыг шинжлэх зэргээр гүйцэтгэхийг үүсгэн шийдвэрлэсэн боловч энэхүү хүртэл завдан гүйцэтгээгүй хоосон хоцорсоор болой” гэж шүүмжилсэн байна. Цааш нь газрын тосыг шинжлэн боловсруулах асуудлыг хөндөн тавьж байжээ.

Бас нарийн судалгааны үндсэн дээр эдийн засгийн бодлого боловсруулах, алба татварыг цэгцлэх, ашигтай худалдаа хийх, ялангуяа тэр үеийн Сангийн яамны ажил төрлийг сайжруулах талаар санаа авууштай олон зүйл хэлж байсан байна. Монгол Ардын Хувьсгалт Намын III их хурал дээр Ж.Цэвээн Сангийн яамны ажлыг шүүмжлэн хэлэхдээ: “... Одоо тус яам Худалдаа үйлдвэрийн, Сангийн, Зам харилцааны ийм гурван яамны ажлыг дангаар эрхлэн хийж байна. ... Сангийн яам одоогоос эхлээд үүрэгт ажлаа тухайлбал, улсын эдийн засгийн бодлогыг судлах, ардын аж ахуйг сайжруулах дэлхийн баялагийг ашиглах зэрэг ажлыг эрхлэн хийвэл зохино. 1923-1924 оны улсын орлого зарлагыг авч үзвэл 5 түм 5 мянга, 1924 онд 2 бумыг тус тус хурааж авсан байна. Гэтэл хувийн эдийн засагтай орнуудад ийм юм үзэгддэггүй. Ер нь шууд бус хураах албан татварыг яв явсаар эд хэрэглэгчид буюу ардуудаас хурааж байна шүү дээ. Учир иймд шууд хураах албан татварыг хөрөнгө чинээ бүхий ба баян хүмүүсээс хураадаг болохоор бид шууд бус татварыг шууд татвараар солих арга зам хайвал зохино.

Ганцхан ой мод авахад жилдээ улсад 8000 янчаан мөнгө гэж бод л доо. Аж үйлдвэр ба гар үйлдвэрийн ажлыг бидний монголчууд гартаа авбал ихээхэн юм хэмнэж чадна. Энэ тухайд Сангийн яам юу ч хийсэнгүй” (6,129) хэмээн тэмдэглэжээ. Цааш нь тэрээр Сангийн яамны ажлыг улс орны эдийн засгийн даацтай бодлого боловсруулахад чиглүүлэх, байгаль орныг хамгаалах талаар тулхтай ажил хийх асуудлыг дэвшүүлжээ.

Тухайлбал, “Засгийн бодлогыг бодож боловсруулах завгүй байна. Сангийн яамны сайд хүлээсэн үүргээ гүйцэтгэхийг чармайж байгаа боловч өөрөө аар саар зүйлээр оролдоод байна. (Жамсрано онож хэлсэнд хүмүүс хөхрөлдөв.) Сангийн яамны сайд элдэв зүйлийн ордер-мордер цохох буюу эсвэл жагсаал ёслолд хэрэглэх хоёр гурван зулзган мод огтолж болох эсэхийг хэдэн цагийн турш хэлэлцээд, улс орны эдийн засгийн бодлогыг бодож боловсруулах завгүй байна.

Гадаадын хүмүүс хэрэм, булга агнаж байна. Үүний уршгаар Хэнтий нутагт булга дуусчээ. Одоо сайн харуул цагдаатай болохын тулд хэдэн мянган янчаан лан мөнгө олгохыг Сангийн яам зөвшөөрөхгүй байна. Бид өөр зүйлд улаан мөнгө хэмнэж байдаг атлаа мөнгөн янчаанаа ихээр алдаж байна. Гадаадын хүмүүс, ялангуяа, хятдууд монголчуудыг даган нүүж доншуурлаад, түүхий эдийг хямд авч байна. Гэтэл манай монголын харилцан туслалцах хоршоо бүх Монголд дэлгэрч чадаагүй байна. Иймд аймгуудад яармаг худалдаа гаргавал зохино.” (6, 129) гэжээ. Өнөө үед ч тэр үед гарч байсан зүйл зарим талаар дахин давтагдаж байгаа нь нэн харамсалтай юм.

Ж.Цэвээн МАХН-ын V их хурал дээр “Хүний уул зорилгыг ард олны тусад хандуулбал баяжихыг хориглож болохгүй” хэмээснийг бүрэн дэмжиж хэлэхдээ: “Манай намын гишүүд өөрийн ажил юугаан боловсронгуй сайтар явуулж, бусад

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

ард олныг хоосруулахгүй нийтдээ тэгш хөрөнгөжихийг хичээх хэрэгтэй. “Баяжих” гэдэг үгийг ганцаар ухаж болохгүй. Олон нийтээр баяжихыг эрмэлзэн утга бөгөөд бусдыг мөлжиж хөрөнгөжвөөс үл болно.

Хэрэв ард түмнээ үгээгүй хоосны туйлд хүргэж цөөхөн хүн баяжваас эцэстээ улс төр мөхөхийн шалтгаан болно” гэж “Баяжихтун” лоозонгийн утга учрыг тайлбарласан байна. Намын удирдлагад байсан Ц.Дамбадорж, Н.Жадамба, Ж.Цэвээн нар эцсийн бүлэгт ардын аж ахуйтны ядуу, доод хэсгийн аж амьдралыг дээшлүүлэх гэсэн нийгэм-эдийн засгийн агуулгатай санаа дэвшүүлж байсан юм.

Түүнчлэн Ж.Цэвээн эдийн засгаа өөд татахын тулд өндөр хөгжилтэй орнуудтай харилцахад зам харилцаа чухал болохыг бүр тэгэхэд мэдэрч, Монгол орныг гадаад их далайд гаргах боломжийн талаар 1908, 1913 онд Хаант Орос Улстай байгуулсан гэрээ хэлэлцээр бусад түүхийн баримтыг иш үндэс болгон сануулж байжээ.

Тэр үед нам, төрийн удирдлагад ажиллаж байсан зарим зүтгэлтэн аж ахуйг эдийн засгийн сонирхол дээр хөтлөн явуулах, үндэсний хөрөнгөлөг этгээд, гадаадын капитал, пүүсүүдийг эдийн засгийг хөгжүүлэхэд идэвхтэй ашиглах, капиталист орнуудтай худалдааны хүрээнд хамтран ажиллах, өр нь нийгмийн байгууллын ялгааг үл харгалзан, нийт хүн төрөлхтний үнэт зүйлсээс суралцах нь чухал ач холбогдолтой гэж үзэж байжээ. Үүнд бас капиталист орнуудын эдийн засгийн амжилт нөлөөлсөн нь эргэлзээгүй биз ээ. Гэвч “Баяжихтун” хэмээх лоозонгийн эдийн засаг агуулга, түүний хэрэгжүүлэхэд гаргасан алдаатай үйл ажиллагаа хоёрыг ялган салгаж, задлан шинжилсэнгүй, мөн хэрэгжүүлж болох үр ашигтай өөр өөр арга замыг ч хайж олж туршсангүй, бүхэлд нь няцаан буруутгаж, “зүүний” адал балмад үйл ажиллагаа газар авч эхэлжээ. Большевикуудын үзэл баримтлалд хувийн өмч, “улсын капитализм” хэмээх тэрхүү санаанууд нь үл нийцэж байсан нь илэрхий бөлгөө.

Ж.Цэвээний “Улс эрх” зохиол, МАН-ын I баримт бичгүүдэд томъёолж байсан үзэл санаа, бурхны шашныг үзэх үзэл бодрол, хоршооллын социализмын үзэл баримтлалаас эргэцүүлэн авч үзэхэд үзэл бодлын хувьд үндэсний ардчилсан үзлээс хувьсгалт ардчилсан үзлийн байр сууринд шилжиж байсныг харуулж байна.

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

Эшлэл, зүүлт

1. Буриад Монголын Шарайд овгийн Жамсраны Цэвээн 1881 оны IV сарын 26-нд төржээ. Тэрбээр Дээд-Үд, Эрхүү, Петербургт бага, дунд, дээд сургуулийг дүүргэсэн байна.

1911-1917 онд Олноо өргөгдсөн Монгол улсын Гадаад явдлын яамны соёл эрхэлсэн түшмэлээр ажиллаж, Монгол улсыг сэргээн мандуулах үйлсэд зүтгэж байв. Тэрбээр МАН-ын анхны баримт бичгүүдийг боловсруулахад голлон оролцож, 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалын эхний жилүүдэд нам, төрийн удирдах ажилд хичээнгүйлэн зүтгэж байжээ.

Ж.Цэвээн Коминтерн, “зүүнтний” хавчилт, шахалтанд өртөн ЗХУ-д буцаж очсон байна. Тэрээр 1932-1937 онд Ленинградод ЗСБНХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнд ажиллажээ. Үүнээс өмнө сайхь эрдэмтэн “Улсын эрх” зохиол болон судалгааны олон өгүүлэл бичиж байсан бөгөөд эрдэм шинжилгээний байгууллагад ажиллахдаа “Дархад, урианхай, дөрвөд, хотон, баяд, ойрад, мянгад захчин, торгууд, хошууд, цахар, дарьганги, казах ястнуудын аж төрөл” ном бичиж, Монгол хууль цаазны дурсгалт бичиг - “Халх журам” –ыг нарийвчлан судалсан байна. Ийм учраас 1936 онд Ж.Цэвээнд хэл шинжлэлийн ухааны докторын зэрэг хүртээж, дараа нь ЗСБНХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүнээр сонгожээ. Тэрээр 1937 онд хилс хэрэгт хэлмэгдэн баригдаж, 1940 онд цаазлагдсан байна. 1956 онд түүнийг цагаатгасан юм.

2. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. I дэвтэр. УБ., 1966 он.
3. РЦХИДНИ. ф-495. Оп. 152. д.28.
4. Основы буддизма. УБ. 1927.
5. МАХН-ын төв архив. ф-1, т-4, хн-99.
6. Монгол Ардын Намын III их хурал. (Дэлгэрэнгүй тайлан). УБ. 1966.